



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох оролцоонд суурилсан холимог аргачлалыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү аргачлал батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг шинэчлэн батлахыг Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нарт, мөрдөж ажиллахыг төрийн өмчийн (100 хувь) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд аргачлалыг мөрдөж ажиллахыг зөвлөсүгэй.

4. Аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ) -т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 05 дугаар сарын 17-ны
өдрийн 177 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ЦАЛИН ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭГ ТООЦОХ ОРОЛЦООНД СУУРИЛСАН ХОЛИМОГ АРГАЧЛАЛ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин хөлсний хэмжээг тухайн компанийн үйл ажиллагааны чиглэл, онцлог, цар хүрээг харгалзан тогтоох бөгөөд цалин хөлсийг оролцоонд суурилсан холимог аргачлалаар тооцох болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү аргачлалыг төрийн өмчийн /100 хувь/ компанийн Төлөөлөн удирдах зөвлөл дагаж мөрдөнө. Төрийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаандаа энэхүү аргачлалыг мөрдөж болно.

1.3. Энэхүү аргачлал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хуралдааны шийдвэр гаргах үйл явцад идэвх, санаачилга, үр дүнтэй оролцуулах зарчимд тулгуурласан болно.

2. Холимог аргачлалаар цалин хөлс тооцох

2.1. Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сарын цалингийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг, эсхүл тухайн салбарын болон салбар дундын хамтын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

2.2. Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороонд ажилласан байдлыг харгалзан нэмэгдэл олгож болно. Нэмэгдлийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг, эсхүл тухайн салбарын болон салбар дундын хамтын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн дүнгийн дөрөвний нэгээс хэтрэхгүй байна.

2.3. Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үндсэн болон цагийн цалин хөлсийг Компанийн засаглалын кодекс, Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан “Төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал”-ын тайлан, түүнд тусгагдсан оролцоонд суурилсан холимог аргачлал, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, тухайн салбарын болон салбар дундын хамтын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэслэн төрийн өмчит компанийн үйл ажиллагааны чиглэл, онцлог, цар хүрээнээс хамааруулж дор дурдсан аргачлал, коэффициентуудад харгалзуулан тогтооно.

2.3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд оролцсон хурал тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр суурь цалинг тооцно. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдааныг тасалсан бол суурь цалинг олгохгүй.

2.3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад энэхүү аргачлалын 2.3.1-д заасан суурь цалин дээр нэмж 10% нэмэгдэл тооцон олгож болно.

2.3.3. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс энэхүү аргачлалын 2.3.1-д заасны дагуу тогтоосон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сарын суурь цалингийн дүнг 5 хуваасны нэгтэй тэнцүү хэмжээний нэмэгдэл цалин хөлсийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон нэг цаг тутамд бодож олгоно.

2.4. Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний оролцоонд суурилсан үндсэн болон цагийн цалинг тооцох холимог аргачлалыг дараах томъёогоор бодож тооцоолно.

$$\text{ТУЗ-ийн гишүүний нэг хуралдааны цалин} = K_0 + ((K_0 \text{ эсвэл } K_C) \times 0.2 \times K_{Ц})$$

K_0 – Засгийн газар букуу Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

K_C – Тухайн салбарын болон салбар дундын хамтын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

$K_{Ц}$ – Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хуралд оролцсон цаг

2.5. Төрийн өмчит компанийн үйл ажиллагааны чиглэл, онцлог, цар хүрээ, ашигт ажиллагааны түвшин, Төлөөлөн удирдах зөвлөл болон гишүүний ажлын гүйцэтгэл, тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнг харгалзан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нар өсгөж, эсхүл бууруулан тогтоож болно.

2.6. Тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хууль, журам болон компанийн дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол цалин хөлс олгохыг зогсоох, эсхүл үүргээ биелүүлээгүй хугацаанд нь хамаарах хувь хэмжээгээр цалин хөлсний хэмжээг бууруулж олгох саналаа Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга танилцуулж, уг асуудалд цалин урамшууллын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

3. Бусад

3.1. Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-д заасан цалин хөлснөөс бусад тусгайлсан хангамж эдлэхгүй.

3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн тэтгэмж олгохыг хориглоно.